



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2022 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

**Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын
хугацаа сунгах тухай**

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан 2 /хоёр/ хуулийн этгээдийн болон 1 /нэг/ иргэний харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилийн хугацаагаар тус тус сунгасугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгагдсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2023 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн
104 тоот тогтоолын
хавсралт

Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа
сунгасан хуулийн этгээд /иргэний/-ийн жагсаалт

№	Хуулийн этгээд /иргэн/ -ийн нэр	Олгосон дугаар	Хугацаа	Дугаарлалтын зориулалт
1	Асгатын гол ХХК	1900-1550	2023.09.01 2025.09.01	Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ
2	Да хүрээ трейд ХХК	1900-1976	2023.10.21 2025.10.21	Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ
3	А.Дуламсүрэн	1900-1908	2023.08.11 2025.08.11	Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ

----- оОо -----